



МОНГОЛ УЛС  
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2023 оны 05 сарын 24 өдөр

Дугаар А/310

Хэрлэн сум

Хагас жилийн мал тооллого явуулах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Статистикийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1 дэх хэсгийн 7.1.в дэх заалт, Малын индексжүүлсэн даатгалын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4 дэх хэсгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Хэнтий аймгийн нутаг дэвсгэрт хагас жилийн мал тооллогын ажлыг 2023 оны 5 дугаар сарын 30-аас 2023 оны 6 дугаар сарын 06-ны хооронд явуулсугай.

2.2023 оны "Хагас жилийн мал тооллого"-ын ажлыг зохион байгуулах аймгийн ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай.

Ажлын хэсгийн

ахлагч:

Л.Батсайхан

Аймгийн Засаг даргын орлогч

Орлогч дарга:

Г.Сэдэдмаа

Статистикийн хэлтсийн дарга

Нарийн бичгийн  
дарга:

Ц.Батхишиг

Статистикийн хэлтсийн мэргэжилтэн

Гишүүд:

Ж.Энх-Амгалан

Хүнс, хөдөө аж ахуйн газрын дарга

А.Гантөмөр

Татварын хэлтсийн дарга

Н.Анхбаяр

Мал эмнэлгийн газрын дарга

Б.Октябрь

Монгол даатгал Хэнтий аймаг дахь  
салбарын захирал

2.Хагас жилийн мал тооллогын ажлыг хуулийн хүрээнд хугацаанд нь чанартай зохион байгуулж, сумдын ажлын хэсэгт арга зүйн зөвлөмж өгч, нэгдсэн удирдлагаар хангаж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч бөгөөд Ажлын хэсгийн ахлагч (Л.Батсайхан)-д үүрэг болгосугай.

3."Хагас жилийн мал тооллого"-ыг засаг захиргааны нэгжид зохион байгуулахад шаардлагатай заавар зөвлөмжийг өгч, тооллогыг нэг зэрэг хугацаанд нь эхлүүлж, чанартай зохион байгуулахад хяналт тавьж тооллогын шивэлт, дүнг эцэслэн боловсруулж, аймгийн ажлын хэсэгт 2023 оны 6 дугаар сарын 15-д мэдээлэхийг Орлогч дарга (Г.Сэдэдмаа)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.ЧОГСОМЖАВ